

БАТЛАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МЯГМАРСҮРЭН

Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөө 2018-2022 он

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аймгийн Эрүүл мэндийн газрын үзэл баримтлал алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын бүтэц зохион байгуулалт, хяналт үнэлгээ хийх аргачлалыг тусгав.

АГУУЛГА

Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд Эрүүл мэндийн газрын даргын удиртгал үг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл
- 1.2 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- 2.1 Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт
- 2.2 Дотоод орчны үнэлгээ
- 2.3 Гадаад орчны үнэлгээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

- 3.1 Эрүүл мэндийн газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго
- 3.2 Эрхэмлэх үнэт зүйлс
- 3.3 Газрын үйл ажиллагааны стратеги зорилтууд
- 3.4 Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- 3.5 Удирдлага, бүтэц зохион байгуулалт
- 3.6 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

- 4.1 Хяналт үнэлгээ зарчим
- 4.2 Хяналт үнэлгээ хийх арга зүй
- 4.3.Хяналт үнэлгээний үзүүлэлтүүд
- 4.4 Хяналт үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

УДИРТГАЛ ҮГ

Эрүүл мэндийн газар нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасны дагуу тус газрын 2018-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсуулан та бүхэндээ толилуулж байна.

Эрүүл мэндийн газар нь өөрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд тулгуурлан нутгийн захиргааны байгууллагын зорилт, чиг үүргийг тодорхойлсон энэхүү стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэр, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх тухайн жилийн үндсэн чиглэлийг удирдлага болгон ажиллана.

Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөг тодорхой шийдвэр гаргахад туслах баримт бичиг байх үүднээс хэлтэс бүр өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлант жилийн үр дүнгийн гэрээ зэрэгт тусган хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын стандартад нийцүүлж эцсийн үр дүнг чухалчлан ажиллах болно.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог улам боловсронгуй болгох үндсэн зарчмыг удирдлага болгон Эрүүл мэндийн газрын 2018-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн стратегийн зорилтыг ханган биелүүлэх, тухайн жилд бүтээгдэхүүн нийлүүлэлтийг зохион байгуулах явцад гарсан ажлын ололт амжилт, үр дүн, хүндрэл бэрхшээлийг аймгийн Засаг дарга тайлагнаж, улмаар олон нийтэд ил тод мэдээлнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МЯГМАРСҮРЭН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2017 оны “Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо батлах тухай” А/122 дугаар захирамжыг тус тус үндэслэн боловсруулав.

1.2 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол

Стратеги төлөвлөгөө нь Эрүүл мэндийн газрын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүчин чармайлт, цаг хугацаагаа юунд төвлөрүүлэх вэ гэдгийг тодорхойлж хамтдаа хөгжих бодлогын баримт бичиг юм.


Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд бидний өмнө ямар асуудал тулгарч байгааг тодорхойлж, түүнийг даван туулах аргачлал, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж үр дүнд хүрэх бодлогын чиглэл болно.

Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгож, эрүүл мэндийн салбарын бодлогын уялдаа холбоо хангагдан, байгууллагын дотоод зохион байгуулалт боловсронгуй болно.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 2010-2014 Аймгийн Засаг даргын захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталж Эрүүл Мэндийн Газар нь 3 хэлтсийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан.





Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын тушаал, Аймгийн Засаг даргын 2017 оны А/122 дугаар захирамжийн дагуу бүтэц, орон тоо шинэчлэгдэн 4 хэлтэс, 25 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс,
- Эмнэлгийн тусламжийн хэлтэс,
- Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс,
- Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс,

2.2 ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Аливаа стратегийн шинжтэй шийдвэр гаргах, төлөвлөгөө боловсруулахын тулд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг дотоод, гадаад орчныг судлах шаардлагатай болдог бөгөөд байгууллагын алсын хараа, урт хугацааны зорилтууд, стратегийн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлоход SWOT шинжилгээг ашигладаг.

Эрүүл мэндийн газрын дотоод орчны шинжилгээг хийхдээ нийт албан хаагчид, хэлтсүүдээс авсан судалгааны дүнг нэгтгэж зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гарсан санал, зөвлөмжийг тусгасан.

(SWOT ШИНЖИЛГЭЭ)

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
1. Эрүүл мэндийн газар нь өөрийн байртай. 2. Нийт албан хаагчдын 60 гаруй хувь 5-аас дээш жил төрд ажилласан туршлагатай боловсон хүчинтэй 3. Байгууллагын ажилчдын нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлдэг	1. Байгууллагын бүтэц зохион байгууллалтыг боловсронгуй болгох, орон тоог нэмэгдүүлэх, давхар ажил эрхлэлтийг бууруулах 2. Удирдлагын зүгээс боловсон хүчнийг дэмжих, хөгжүүлэх тал дээр анхаарах 3. Шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэх

<p>4. Байгууллагын дотоод уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг</p> <p>5. Эрүүл мэндийн салбартаа олон жилийн түүх, туршлагатай байгууллага</p>	<p>4. Хэлтсүүдийн хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцох байдлыг сайжруулах</p> <p>5. Чадварлаг боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах, урамшуулах хөшүүрэг хангалтгүй.</p>
<p>Боломж</p>	<p>Аюул</p>
<p>1. Хүний нөөцийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх</p> <p>2. Боловсон хүчнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах</p> <p>3. Хувь хүний хөгжлийг дэмжих</p> <p>4. Мэргэжлийн чиглэлээр албан хаагчдыг гадаад, дотоодын туршлага судлах боломжоор хангах</p> <p>5. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах</p> <p>6. Хэлтсүүдийн үйл ажиллагааг уялдуулах зорилгоор тогтмол мэдээллийн цагтай болох</p> <p>7. Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах, ажилтны чадавхийг бэхжүүлэх, хөгжүүлэх.</p>	<p>1. Зохион байгуулалтын шинэ бүтцийг төлөвшөөгүй байхад нь өөрчлөх</p> <p>2. Бусад мэргэжилтнүүдийн чиг үүргийн давхардал гарах</p>

2.3 ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ


Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад гадаад орчны хүчин зүйлсийн нөлөөлөл, шалтгааныг шинжлэх шаардлагатай байдаг. Тодруулбал, газрын үйл ажиллагаанд Аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Хурлын дэмжлэг ямар хүчин зүйлүүд дээр хэрэгтэй, эдгээр хүчин зүйлсийн хувьд аймаг ямар давуу талуудтай зэргийг тодорхойлон гаргахад чиглэдэг.

БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны хүчин зүйл	Тайлбар
Улс төрийн хүчин зүйлс	<p>Эрүүл мэндийн тухай хуулийг шинэчлэх</p> <p>Сонгуулийн үр дүнгээс үл шалтгаалж эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах</p>
Эдийн засгийн хүчин зүйлс	<p>Улсын төсвөөс Эрүүл мэндийн газарт олгох санхүүжилтийг өсгөх</p> <p>Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах</p>
Нийгмийн хүчин зүйлс	<p>Хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулах, түр оршин суугчдын асуудлыг зохицуулах</p> <p>Ажлын байрны хангамж дээшилж, цалин, тэтгэвэр, халамжийг сайжруулах</p>

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

3.1 Эрүүл мэндийн газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго



3.2 Бидний эрхэмлэх үнэт зүйлс:

3.2.1 Мэдлэгийг эрхэмлэх: Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлнэ.

3.2.2 Чадварыг эрхэмлэх: Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.

3.2.3 Хууль ёсыг эрхэмлэх: Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.

3.2.4 Ёс зүйг эрхэмлэх: Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.

3.2.5 Шударга ёсыг эрхэмлэх: Газрын үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.

3.2.6 Соёлтой харилцааг эрхэмлэх: Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа, үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.

3.2.7 Үнэнч байдлыг эрхэмлэх: Төрийн албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандаж, албан үүргээ аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.

3.2.8 Шуурхай байдлыг эрхэмлэх: Газрын үйл ажиллагааг явуулахад бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд нэн анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.

3.2.9 Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх: Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.

3.2.10 Бүтээлч байдлыг эрхэмлэх: Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.

3.2.11 Багийн ажиллагааг эрхэмлэх: Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.

3.3 Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны стратеги зорилтууд

Эрүүл мэндийн газар нь өөрийн чиг үүрэг, эрхэм зорилгоо хангахын тулд стратегийн дараах зорилтыг дэвшүүлж байна.

Стратегийн зорилт 1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, тогтвортой хөгжлийг зорилтын хэрэгжилтийг ханган, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах

Хүрэх үр дүн

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- “Төрөөс эрүүл мэндийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгнө.

Стратегийн зорилт 2. Байгууллагын бүтэц зохион байгуулалт, төлөвлөлтийн эрх зүйн орчин, дүрмийг эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн өнөөгийн болон хэтийн эрэлт, шаардлагад нийцүүлэн сайжруулах

Хүрэх үр дүн

- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хууль эрх зүйн орчин сайжирна.
- Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөж хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Стратегийн зорилт 3. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийг хангаж, ажлын байрны давхардалтыг бууруулж, ээлтэй орчин бүрдүүлэх

Хүрэх үр дүн

- Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийн ажиллах урам зориг бүхий дэмжлэгт орчин бүрдэнэ.

Стратегийн зорилт 4. Төрийн байгууллагын удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, газрын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн

- Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлж хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туслах, хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна.

- Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулан ажилтны чадавхийг бэхжүүлэн хөгжүүлнэ.

Стратегийн зорилт 5. Эрүүл мэндийн газрын чиг үүрэгтэй холбоотой гарсан хууль тогтоомж, бодлогын зорилт, тусгай захиалгат ажлын биелэлтийг тайлагнан, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах

Хүрэх үр дүн

- Эрүүл мэндийн газрын үндсэн чиг үүргийн хүрээнд дээд газраас өгсөн цаг үеийн шинж чанартай ажлыг түргэн шуурхай гүйцэтгэнэ.
- Дээд газартай байгуулсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг цаг тухай бүр нь ханган ажиллана.

3.4 Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Стратегийн зорилт	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Стратегийн зорилт 1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, тогтвортой хөгжлийг зорилтыг хэрэгжилтийг ханган, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ, сум, өрхийн эрүүл мэндийн төв	2017-2021
	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар эрүүл мэндийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ, сум, өрхийн эрүүл мэндийн төв	2017-2021
	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн биелэлт, үр дүнг тооцож ажиллах.	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ, сум, өрхийн эрүүл мэндийн төв	2017-2021
Стратегийн зорилт 2. Байгууллагын бүтэц зохион байгуулалт, төлөвлөлтийн эрх зүйн орчин, дүрмийг эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн өнөөгийн болон хэтийн эрэлт, шаардлагад нийцүүлэн сайжруулах	“Байгууллагын стратеги төлөвлөгөөг” боловсруулж, хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд, эрүүл мэндийн байгууллагууд	2017-2022
	Байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгоо тодорхойлж, ажилтан бүрт ухамсарлуулан ойлгуулах	Эрүүл мэндийн газар, ХШҮМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022
	Байгууллагын гадаад, дотоод өнгө үзэмж, тав тухтай байдал, орчин нөхцөлийг сайжруулах, тэдгээрийг үнэлэх шалгууруудыг бий болгох	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022

	Эрүүл мэндийн байгууллагуудын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, шинэчлэн боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд, эрүүл мэндийн байгууллагууд	2018-2022
Стратегийн зорилт 3. Байгууллагын хүний нөөцийн хөгжлийг хангаж, ажлын байрны давхардалтыг бууруулж, ээлтэй орчин бүрдүүлэх	Үндсэн мэргэжилтэн болон туслах ажилтнуудын зохистой харьцаа бүрдүүлэх	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
	Хүний нөөцийн төлөвлөлт хийх чадавхийг бүрдүүлэх сургалтыг албан хаагч нарт зохион байгуулах	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
	Байгууллагын ажилтан ажилд авах, сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг үнэлэх, шагнал урамшил олгох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нэгдсэн журам гарган, хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
	Эрүүл мэндэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжигч, эрүүл ажлын байр бүрдүүлэх	Эрүүл мэндийн газар, НЭМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
	Мэргэжилтнүүдийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ажлын байран дээрээ хөгжих нөхцлийг бүрдүүлэх, суралцагч байгууллага болох	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
	Байгууллагын албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах	Эрүүл мэндийн газар, ЭМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022

	Эрүүл мэндийн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт”-ыг хэрэгжүүлж ажиллах	Эрүүл мэндийн газар, ЭМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2018-2022
Стратегийн зорилт 4. Төрийн байгууллагын удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, газрын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх	Төрийн болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022
	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022
	Хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туслах, хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах	Эрүүл мэндийн газар, УТС-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022
	Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар сургалт зохион байгуулах, ажилтны чадавхийг бэхжүүлэх, хөгжүүлэх	Эрүүл мэндийн газар, ЭТ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд, Эрүүл мэндийн байгууллагууд	2017-2022
	Албан хаагчийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, үр дүнгийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж үнэлэх	Эрүүл мэндийн газар, ХШҮМ-ийн хэлтэс	Бусад хэлтсүүд,	2017-2022

<p>Стратегийн зорилт 5. Эрүүл мэндийн газрын чиг үүрэгтэй холбоотой гарсан хууль тогтоомж, бодлогын зорилт, тусгай захиалгат ажлын биелэлтийг тайлагнан, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах</p>	<p>Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргах</p>	<p>Эрүүл мэндийн газар, ХШҮМ-ийн хэлтэс</p>	<p>Бусад хэлтсүүд,</p>	<p>2017-2022</p>
---	--	---	------------------------	------------------

3.5 Эрүүл мэндийн газрын удирдлага, бүтэц зохион байгуулалт


Эрүүл мэндийн газрыг байгуулах, өөрчлөх асуудлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар, бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны дүрмийг аймгийн Засаг даргын захирамжаар батална.

Байгууллага дахь зохион байгуулалтын, хэлтсүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг нарийвчлан зохицуулсан дүрмийг газрын дарга батална.

Аймгийн Засаг дарга нь газрын даргыг томилж, чөлөөлнө. Эрүүл мэндийн газрын дарга нь газрын хэлтсийн дарга, албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

3.6 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц Газрын бүтэц зохион байгуулалтын загвар

Схем 1



Аймгийн Засаг даргын 2017 оны А/122 дугаар захирамжаар аймгийн Эрүүл мэндийн газар нь нийт 43 албан хаагчийн орон тоотой байхаар батлагдсан бөгөөд газрын дарга, хэлтсийн дарга, 4 хэлтэстэй байхаар зохион байгуулалтын бүтцийг баталсан. 2018 оны байдлаар 4 хэлтэстэй 25 орон тоотой ажиллаж байна.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх дотоод үйл ажиллагааны загвар

Схем 2



Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэрийн хувьд эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, ажилтан болон байгууллагын зүгээс жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах замаар үндсэн бодлогын ажлуудыг хэрэгжүүлнэ. Мөн эрүүл мэндийн газрын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн газар нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын захирамж, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

Мөн ажлын тайланг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын асуудлыг нэгтгэн зохион байгуулах үүргийг хүлээж, аймгийн харьяа байгууллагуудыг хууль эрх зүйн мэдээллээр ханган хамтран ажиллана.

ДӨРӨВ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим:

4.1.1. Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үе шаттайгаар үнэлгээ өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан ажиллана.

4.1.2. Газрын стратеги төлөвлөгөөг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгуулах, явцын хяналтыг тогтмол хийх үүргийг удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс хариуцан ажиллана.

4.1.3. Газрын стратеги төлөвлөгөөнд явцын хяналт хийж, бүтэн жилээр биелэлтийг дүгнэх нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад оршино.

4.1.4. Урьдчилсан болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.

4.1.5. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг газрын даргын тушаалаар байгуулагдсан хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

4.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

4.2.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг газрын дарга батална.

4.2.3 Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ хагас бүтэн жилээр гаргасан тайлан, мэдээтэй танилцаж баримт бичгийг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

4.2.4 Бодлогын зорилтын хэрэгжилтийн төвшинг тодорхойлоходоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Гүйцэтгэл) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (Зорилт) харьцуулж хувиар илэрхийлнэ. (Г/Зх100).

4.2.5 Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална.

Үүнд:

4.2.5.1 тавьсан зорилтод бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь

4.2.5.2 тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-89.0 хүртэл хувь)

4.2.5.3 тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 40.0 хувь (31.0-59.0 хүртэл хувь)

4.2.5.4 тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь)

4.2.5.5 тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.

4.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд:

4.3.1 Газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийг батлах, төсвийн тодотгол хийхээс өмнө үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өртгийг нь тооцож, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

4.3.2 Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн, үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

4.3.3 Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилийн улсын статистик мэдээллээр гаргасан үзүүлэлт, төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж нийтэд мэдээлсэн тоон мэдээ зэргийг суурь үзүүлэлт болгон авна.

4.3.4 Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.4.1 Хамааралтай буюу ач холбогдолтой байх

4.3.4.2 Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх

4.3.4.3 Хэрэглэхэд хялбар, боломжтой байх

4.3.4.4 Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх.

4.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

4.4.1 Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.4.1.1 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

4.4.1.2 Газрын стратеги зорилтоос хариуцсан чиглэлийн хүрээнд албан хаагчид өөрийн үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх

4.4.1.3 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд стратегийг хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулах үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодотгох.

-----oOo-----